



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 5108

Улаанбаатар хот

Д.Даваадоржийг ажилд томилох тухай

Монгол Улсын “Төрийн албаны тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.12 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/45 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Доржжанцан овогтой Д.Даваадоржийг Хяналт, үнэлгээний хэлтсийн даргын албан тушаалд 2013 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн нэг жилийн туршилтын хугацаагаар томилон ажиллуулсугай.

2. Д.Даваадоржийн сарын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээний дагуу /ТЗ-8-1/ 555.673 /таван зуун тавин таван мянга зургаан зуун далан гурван/ төгрөгөөр цалинжуулж, холбогдох журмын дагуу унаа, хоолны хөнгөлөлтийг олгохыг нягтлан бодогч / П.Ариунаа /-д зөвшөөрсүгэй.

3. Д.Даваадоржийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ц.Цог/ - т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.БАТСАЙХАН

